



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/24

Чойбалсан

Г

Хөрөнгө зарцуулах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.5 "в", 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.1, 3.1, 4.3, Аймгийн онцгой комиссын 3 дугаар хуралдаан, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар /COVID-19/ цар тахлын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, шуурхай арга хэмжээ авах ажлын хүрээнд Чулуунхороот сумын Эрээнцав өртөөний хяналтын постод хамгаалалтын ажлыг зохион байгуулан ажиллаж буй цагдаагийн алба хаагчдын хоол, хүнс, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон түлш, халаалтын зардалд шаардагдах 1.704.600 /нэг сая долоон зуун дөрвөн мянга зургаан зуу/ төгрөгийг хавсралтаар баталсугай.

2.Зардлын 1,704,600 / нэг сая долоон зуун дөрвөн мянга зургаан зуу/-н төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /П.Бат-Өлзий/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Ганбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

Аймгийн Засаг даргын 2021 оны
01 дүгээр сарын 18-ны өдрийн
11/21 дугаар захирамжийн хавсралт



ЧУЛУУНХОРООТ СУМЫН ТӨМӨР ЗАМЫН ПОСТОД
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДАД
ШААРДЛАГАТАЙ ЗАРДАЛ

№	Зардлын төрөл	Алба хаагчдын тоо	1 өдрийн зардал	Ажиллах хоног	Нийт зардал /төгрөг/
1	Түлш, халаалт /5т*20.000/	3		30	250.000
2	Алба хаагчдын хоол хүнс	3	11.600	30	1.044.000
3	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3		30	410.600
Нийт зардал					1.704.600